

Олон зууны туршид нүүдлийн мал аж ахуйн үндэс суурь болсоор ирсэн бэлчээрийн газар урьдын адил үржил шимтэй байхаа больжээ. Үүний гол шалтгаан нь бэлчээрийн талхагдал юм. Бэлчээрийн доройтолд байгаль, цаг уурын оорчлолтоос гадна хүний хүчин зүйл ихээхэн нолоо үзүүлж байна. Мал маллаж амьжиргаагаа залгуулдаг малчин орхийн тоо 1990 онд 90 мянга байсан бол одоо 170 мянгад хүрч, хүн амын 1/3-тэй тэнцэх болсон нь 1990-ээд оны туршид улсын үйлдвэрийн газрууд дампуурч, олон хүн ажилгүй болсноос үүдэлтэй. 1990 оноос хойш гарсан нийгмийн оорчлолт, шинэчлэл бэлчээрт тавих хяналтыг зохицуулалтгүй болгож, нийтийн нооцийг чолоотэй, дур зоргоор ашиглуулахад хүргэсэн юм. Хэт олон тооны малтай болж бэлчээрийн тэжээлийн толоо орсолдох болсон нь хөрс, овс ургамал, усны нооцод хохирол учруулж бэлчээрийн чанар нь буурч, хомсдож байна. Үүний улмаас мах, ноосны чанар муудаж, малчдын орлого буурснаар малчид буурсан орлогоо малынхаа тоог осгох замаар нохох болов. Таван малчин орхийн хоёр нь ядуу зүдүү амь зууж байгааг албан ёсны статистикийн мэдээ харуулж байна. Энэ байдал хэвээр үргэлжилбэл улам олон малчин орхийг ядууралд түлхэн оруулж, үндэсний хүнсний аюулгүй байдлыг бусниулж, бэлчээрийн газрыг цол болгон хувиргах болно.

Швейцарь болон Монгол улс 2004 оноос хойш ядуурлыг бууруулах, экологийн сорог оорчлолтийг багасгах чиглэлээр хамтран ажиллаж байна. Энэхүү үр бүтээлтэй харилцаа нь хөгжлийн цогц хотолбор - Ногоон алт тослийн анхаарлын товд байгаа бэлчээрийн мал аж ахуйд тулгарч буй олон асуудлыг шийдвэрлэхийн толоо Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны агентлаг Монголын засгийн газрын яамд, ард түмэнтэй хамтран ажиллаж байгаагаар илэрч байна.

Ногоон алт тосол ШХА-ийн мал аж ахуй, зах зээл, цолжилттэй холбоотой бусад тосол, түүнчлэн Монголын засгийн газрын зорилт, зорилгыг уялдуулан зангидаж, ходоогийн амьжиргааны твшин, малчдын хамтын нийгмлэгүүдийн үндэс суурь болсон бэлчээрийн газрыг тогтвортой ашиглахад үйл ажиллагаагаа чиглүүлж байна.

“Ногоон алт” тосол орлогыг нэмэгдүүлэхийн тулд бүтээмжийг дээшлүүлэхийн зэрэгцээ бэлчээрийн экологийн хязгаарлалтыг тэнцвэрт байдалд оруулан бэлчээрийг сэргээх малчдын амьжиргааны твшний тогтвортой, уян хатан байдлыг хангах ноцол, чадавхийг Монголын иргэдэд бий болгохыг зорьж байгаа юм. Тосол 2004 оноос эхлэн 3 үе шаттайгаар хэрэгжиж байна.

- **2004-2008 он - I үе шат**
- **2009 он - Завсрын үе шат**
- **2010-2012 он - II үе шат**

Ногоон алт тосол I шатандаа нийтийн бэлчээрийг дундаа ашигладаг малчдын оорийгоо удирдах байгууллагыг бий болгож, бэхжүүлснээр бэлчээрийг зүй зохистой ашиглаж хамгаалан нохон сэргээх боломжийг бүрдүүлэх туршилтын хотолборийг экологийн оор оор бүсийн 5 суманд хэрэгжүүлж туршсан юм. Энэ хугацаанд жижиг, хагас албан шинжтэй бүлгүүд томоохон, албан ёсны Бэлчээр Ашиглагчдын Хэсэг (БАХ) болон нэгдэв. Малчид энэ БАХ-үүдээр дамжуулан бэлчээрийн тогтвортой менежмент хийх сонирхолтой бусад талууд, орон нутгийн захиргаатай хамтран нийтийн омч болсон бэлчээрийн газраа ашиглаж эхлэв. Туршилтын үр дүн зүй зохистой ашиглалт хамгаалалтыг бүрдүүлснээр бэлчээрийн толов байдлыг хэвийн хэмжээнд байлгах, малчдын амьжиргааг дээшлүүлэх цорын ганц арга зам бол малчдын оорийгоо удирдах байгууллагыг бий болгож малчин түмэн, иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн засаг захиргааны хамтын ажиллагааг хангах явдал юм гэдгийг харууллаа. Ногоон алт төслийн энэ үзэл баримтлал 8 аймгийн 55 суманд хэрэгжиж эхлээд байна.

Монгол орны үндэсний хөгжлийн стратеги, Ногоон алт төсөл

- УИХ 2021 он хүртэлх Үндэсний хөгжлийн стратегийг 2008 онд баталжээ. Энэ баримт бичгийг НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилт (МХЗ), түүнчлэн бодлогын чанартай 304 илтгэлд орсон дэвшилтэд хэсгүүдэд түшиглэн боловсруулсан байна. Энэ баримт бичгийн стратегийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь “бэлчээр ашиглалтын зохистой менежментийн систем” юм. “Ногоон алт” тосол энэхүү стратегийн байгаль орчны; засаглалын; эдийн засгийн; нийгмийн гэсэн дорвон зохилтод нолоолох юм.

- Байгаль орчин - Ногоон алт төслийн үйл ажиллагаа бэлчээрийн газрын доройтлын чиг хандлагыг бууруулах, зогсоход хувь нэмэр оруулна;

- Засаглал - “Ногоон алт” тосол Засгийн газрын хүсэлтээр бэлчээр ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн тосол боловсруулах, эрх зүйн орчин бүрдүүлэхэд дүн шинжилгээ хийх, зовломж гаргах, идэвхитэй оролцох байдлаар хувь нэмэр оруулж байна. Орон нутгийн түвшинд Ногоон алт төслийн хөгжүүлэн бэхжүүлсэн бэлчээр ашиглагчдын хэсгүүд орон нутгийн удирдлагад малчны хамтын нийгэмлэгийн оролцоог нэмэгдүүлж, үр огоожийг нь дээшлүүлж байна.

- Эдийн засаг - Малчид, БАХ-үүд, хандивлагч орнуудын болон ШХА-ийн Мал аж ахуй тосол, ходоогийн бизнес эрхлэгчдэд зах зээлийн боломж олгох төслийн хоорондох хамтын ажиллагааг дэмжих “Ногоон алт” төслийн төлөвлөгөө нь хувийн хэвшлийг дэмжих, эдийн засгийн осолтийг түргэтгэх эдийн засгийн тулгуур ашиг сонирхлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах итгэл найдвэр төрүүлж байна.

- Нийгэм - “Ногоон алт” төслоос БАХ-ийн дундын санд оруулж байгаа Дэмжих сан нэмэлт орлого олох үйл ажиллагаа, санаачилгаа хэрэгжүүлэх, ахуй

амьдралын тулгамдсан хэрэгцээгээ (эрүүл мэнд, сургууль соёл) хангахад нь зориулан малчдын хамтын нийгэмлэгүүдэд боломжийн зээл олгох бололцоог сайжруулж нийгмийн халамжаас хүртэх нохцлийг бүрдүүлнэ.

Мянганы хөгжлийн зорилт, Ногоон алт төсөл

- Монгол улсын засгийн газраас хөгжлийн стратегитаа тусгаж авсан Мянганы хөгжлийн зорилтуудыг “Ногоон алт” тосол дэмжинэ.
- Мянганы хөгжлийн зорилт - 1. Ядууралтай тэмцэх: Ногоон алт тосол орлого нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад туслах бусад үйл ажиллагааг явуулна.
- Мянганы хөгжлийн зорилт - 3. Хүйсийн харьцаа: Төслийн багийнхан болон твшүүд эмэгтэйчүүд алив үйл ажиллагаанд тэгш эрхтэйгээр, чолоотэй оролцоно гэдгийг ухамсарлан ойлгож, хүлээн авах болно.
- Мянганы хөгжлийн зорилт - 7. Байгаль орчин: Доройтсон бэлчээрийг нохон сэргээж, баялгийг нь хадгалан хамгаалах үүднээс бэлчээрийн газрын чадавхид нийцүүлэн мал аж ахуй эрхэлж, байгаль орчноо тогтвортой хамгаалж ашиглахад нь хүмүүст тусална.